



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/626

Булган сум

### Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай

Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Булган аймгийн Бүрэгхангай сумын Дэрст багийн иргэн Дуламсүрэн овогтой Цэрэнтогтох нь бие даан амьдрах чадваргүй, тусгай нөхцөл шаардсан хүнд хэлбэрийн оюуны хомсдол өвчтэй (DS/F72.0), хөдөлмөрийн чадвар алдалт 80 хувьтай хөгжлийн бэрхшээлтэй иргэн тул Хөвсгөл аймаг дахь "Ахмад настны асрамж, үйлчилгээний төв"-д шилжүүлэн асруулсугай.

2. Д.Цэрэнтогтохыг Хөвсгөл аймаг дахь "Ахмад настны асрамж, үйлчилгээний төв"-д хүргэж, хүлээлгэн өгөхийг Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга (Н.Батжаргал), Бүрэгхангай сумын Засаг дарга /М.Бадам/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ